Таалал тогссон Их Удирдагч Ким Жонг Илийн чандарыг нийтэд болон гадаадын жуулчдад vзvvлнэ гэж байсан Хойд Солонгосын тал, онгорсон 21-ний одроос эхлэн амлалтандаа хvрч эхэллээ.

Хятадын " Young Pioneer Tours " хэмээх жуулчны компани Хойд Солонгос улсад гадаадын болон хятадын жуулчдыг аялуулдаг богоод тэднээр дамжуулан гадаадын жуулчид анх удаагаа эцэг , хvv нарын чандар байрлах Кымсv ууланд дурсгалын цогцолборт зочилжээ.

Яг л унтаж буй мэт шилэн хоргоны цаана харагдаж буй Их Удирдагч Ким Жонг Илийн чандарыг vзэхээр очсон жуулчдаас чандарын омно заавал бохийн мэндчилж хvндэтгэл vзvvлэх шаардлагыг тавих богоод хоргоны хажууд 4 буутай цэрэг хамгаалалтанд зогсож , чанга ярих хориотой тул чихэнд зvvлгэсэн микрофоноор англи хэл дээрх орчуулга сонсоно гэнэ.Уг цогцолборт орохоос омно жуулчдын гутлыг автомат цэвэрлэгчээр цэвэрлэн ,омссон хувцасных нь тоосыг авдаг богоод vvний дараа буу зэвсэг байгаа эсэхийг шалгаж 90 минутийн хугацаанд уг цогцолборыг vзvvлж дуусгадаг ажээ.

Хойд Солонгос улсыг vvсгэн байгуулагч Ким Ил Сений чандарыг таалал тогссонийх нь 1 жилийн дараа торийн ондор албан тушаалтнуудад, 2 жилийн дараа зовхон оорийн орны иргэддээ vзvvлж байсан бол энэ удаа тvvний хvvгийн чандарыг талийгч болсных нь 1 жилийн дараа гадаадын иргэдэд vзvvлж байгаа юм байна.